

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН  
2023 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2023.12.05

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	8	9
<b>СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: ТАТВАР ТӨЛӨГЧ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ТАТВАР ТӨЛӨХ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ, ЭРХЭЭ ЭДЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЖ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ</b>							
<b>НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>							
1	Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэн 100 хувьд хүргэнэ		Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Төсвийн орлого 12301580.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 13468796.0 мянган төгрөг төвлөрүүлж 109 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа.	100
1.1	Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх		Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Улсын төсвийн орлого 1968998.0 мянган төгрөгийн төлөвлөгөө биелүүлэхээс 2496395.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 127 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
1.2	Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр биелүүлэх		Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Аймгийн төсвийн орлого 1155590.0 мянган төгрөгийн төлөвлөгөө биелүүлэхээс 1654475.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 143 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
1.3	Сумын төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр биелүүлэх		Сумын төсвийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Сумын төсвийн орлого 9176992.0 мянган төгрөгийн төлөвлөгөө биелүүлэхээс 9317926.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 102 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
1.4	Цалингийн орлогын төлөвлөгөөний биелэлт		Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Цалингийн орлогын төлөвлөгөө 5525708.0 мянган төгрөгийн төлөвлөгөө биелүүлэхээс 5802383.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 105 хувийн гүйцэтгэлтэй байна	100
1.5	Татварын орлогын 2023 оны төлөвлөгөөг 2 хувиар давуулан биелүүлэх.		Давсан орлогын дүн	2	2	Төсвийн орлогын бүрдүүлэлт 2022 онд 12038935.0 мянган төгрөг бүрдүүлж байсан бол 2023 онд 13468796.0 мянган төгрөг бүрдүүлж өмнөх мөн үеийн үзүүлэлтээс 12 хувь нэмэгдэж гүйцэтгэлийг бүрэн хангаж ажилласан.	100

1	2	3	4	5	6	7	8
2	Татварын тайлангийн ирцийг 95 хувьд хүргэнэ.		Тайлангийн ирцийн хувь	88	95	Тайлант жилд нийт 4099 тайлан хүлээн авахаас 3984 тайлан хүлээн авч 97 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
2.1	Татварын тайлан ирүүлбэл зохих татвар төлөгчийн сар, улирал, жилийн тайлангуудыг хуулийн хугацаанд хүлээн авах		Цахимаар ирүүлсэн тайлангийн хувь	96	97	Татвар төлөгчийн татварын тайланг 100 хувь цахимаар хүлээн авч байна. Үүнээс: 1.Суутган-1 татварын тайлан 1069 татвар төлөгч ирүүлэхээс 965 нь буюу 90.3 хувь, 2. Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн 2944 тайлан хүлээн авахаас 2937 тайлан хүлээн авч 99.76 хувь, 3.Дотоодын архины онцгой албан татварын 11 тайлан хүлээн авахаас 11 тайлан хүлээн авч 100 хувь 4. Ашигт малтмал нөөц ашигласны төлбөрийн тайлан 54 тайлан хүлээн авахаас 52 тайлан хүлээн авч 96.3хувь, 6. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 21 тайлан хүлээн авахаас 19 тайлан хүлээн авч 90.47 хувь хүлээн авсан байна. Нийт 4099 тайлан хүлээн авахаас 3984 тайлан хүлээн авч 97.19 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
2.2	Татварын тайлан боловсруулалт, зөрчилтэй тайланг бүрэн засварлуулах		Засварласан тайланг хүлээн авсан хувь	83	95	Тайлант хугацаанд нийт 258 тайлан залруулан хүлээн авахаас 246 тайланг залруулж нийт 96 хувьтай байна.	100
2.3	Татвар төлөгчийн цахимаар ирүүлсэн хүсэлтийг хуулийн хугацаанд багтаан шийдвэрлэх		Хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн хувь	86	95	Нийт 4167 хүсэлтийг цахимаар ирүүлснээс нийт 3959 бүрэн шийдвэрлэж гүйцэтгэл 95хувьтай байна.	100

1	2	3	4	5	6	7	8
3	Татвар төлөгчийн баазыг нэмэгдүүлнэ		Татвар төлөгчийг бүртгэл нэмэгдсэн хувь	100	100	Тайлант хугацаанд бүртгэгдвэл зохих давхардсан тоогоор 46755 татвар төлөгчийг 100 хувь бүртгэж бааз суурийг 3.3 хувиар нэмэгдүүлсэн байна.	100
3.1	Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдийг бүртгэх		Бүртгэгдвэл зохих татвар төлөгчийг бүртгэсэн хувь	100	100	Улсын бүртгэлийн хэлтэст бүртгүүлэн бүртгэгдвэл зохих 56 хуулийн этгээдийг 100 хувь бүртгэсэн	100
3.2	Татварын бааз суурийг 2 хувиар нэмэгдүүлэх		Бааз суурийг нэмэгдүүлсэн тоо	45245	46115	Давхардсан тоогоор татварын төрлийн бүртгэлд 1217 иргэн, хуулийн этгээд 90 татвар төлөгчийн 202 төрөл нийт 1419 төрөл нэмэгдэж 46664 татвар төлөгчийн төрлийн бүртгэлээрээ бүртгэгдэж зорилтот түвшинг хангасан байна.	100
3.3	Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн тоог нэмэгдүүлэх		Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн тоо	27	35	Борлуулалтын орлого 50 сая төгрөг давж босго давж бүртгүүлсэн 16, сайн дураараа бүртгүүлсэн 19 нийт 35 татвар төлөгч нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгэгдэж зорилтот түвшинг хангасан байна	100
3.4	ПОС машинд аж ахуйн нэгжийн данс холбуулах ажлыг холбогдох байгуулагатай хамтран зохион байгуулах		Зохион байгуулсан арга хэмжээний тоо		1	Нийт 83 хуулийн этгээдэд сургалт зохион байгуулан ажиллаж байна. Баянжаргалан, Өндөршил, Өлзийт, Сайхан-овоо, Хулд, Эрдэнэдалай зэрэг сумдад газар дээрхи сургалтыг зохион байгуулсан. Монгол банкинд байгууллагын дансыг холбох албан бичиг хүргүүлж хамтран ажилласан.	100

1	2	3	4	5	6	7	8
4	Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг ханган 90 хувьд хүргэнэ		Хяналт шалгалтын хэрэгжилтийн хувь	83	90	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт 99 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Зорилтот түвшинг бүрэн хангасан байна	100
4.1	Төлбөрийн баримт олголтыг нэмэгдүүлэх		Төлбөрийн баримтын олгосон татвар төлөгчийн тоо	4651	5000	Бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй 5103 татвар төлөгч 2.4 сая төлбөрийн баримт олгож 2470 азтан тодорсон байна.	100
4.2	Иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлыг шийдвэрлэх		Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь	100	100	Нийт ЗГ-ын 1111 төвд 2, ибаримтаар 217 нийт 219 гомдол татвар төлөгчдөөс ирүүлсэн бөгөөд 212 гомдлыг бүрэн барагдуулж 7 гомдол шалгагдах шатандаа байна. Гомдол барагдуулалт 97 хувийн гүйцэтгэлтэй байна.	97
4.3	Төлбөрийн баримт олгоогүй татвар төлөгчид хуулийн хариуцлага тооцох		Хариуцлага тооцсон татвар төлөгчийн тоо	65	15	Тайлант хугацаанд хуулийн хэрэгжилтийг хангаагүй 16 татвар төлөгчийг 12.6 сая төгрөгөөр торгосон.	100
		Торгуулийн дүн /сая төгрөгөөр/	31.2	12			
5	Татварын өрийн барагдуулалтыг 80 хувьд хүргэнэ		Татварын өрийг барагдуулалтын хувь	60	80	Тайлант онд нийт 10011745.4 мянган төгрөгийн өрийг барагдуулахаас 8914000.6 мянган төгрөгийн өрийг барагдуулж нийт барагдуулалт 89 хувьтай байгаа нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг 100 хувийг ханган ажиллалаа	100
5.1	Татварын тайлант оны тайлангаархи өрийг барагдуулах		Тайлангаар ногдсон татварын өрийн барагдуулалтын хувь	90	90	Тайлангаар ногдсон 9474688.8 мянган төгрөгөөс 8527319.9 мянган төгрөгийн өрийг барагдуулж өрийн барагдуулалт 90.4 хувьтай байна.	100
5.2	Татварын тайлант оны хяналт шалгалтын өрийг барагдуулах		Тайлант оны хяналт шалгалтын татварын өрийн барагдуулалтын хувь	30	70	Хяналт шалгалтаар ногдсон 537056.6 мянган төгрөгөөс 386680.75 мянган төгрөгийн өрийг барагдуулж өрийн барагдуулалт 72 хувьтай байна.	100

1	2	3	4	5	6	7	8
<b>ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ</b>							
1	Татвар төлөгчдийг татварын боловсролыг нэмэгдүүлнэ.	ОНТ 29.3 сая	Мэдээлэл түгээн ажилласан хувь	100	100	Татвар төлөгч болон албан хаагчдад төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сургалт сурталчилгааг хийж хэрэгжилтийг 100 хувийн гүйцэтгэлтэй ханган ажиллаж зорилтот түвшинг ханган ажилласан байна.	100
1.1	Татварын хууль тогтоомжийг сурталчлах сургалт зохион байгуулах		Зохион байгуулсан сургалтын тоо	4	8	Тасгийн дарга Ч.Оюунжаргал, Н.Мөнгөнтуяа, ТУБ Э.Зулцэцэг, Б.Ууганбат, М.Мөнхбаяр. сумдын татварын улсын байцаагч нар 9 удаагийн сургалт хийж нийт 214 татвар төлөгч сургалтад хамрагдсан	100
			Сургалтад хамрагдсан татвар төлөгчийн тоо		200		
1.2	Татвар төлөгчийн татварын хууль, тогтоомжийн чиглэлээр гарын авлага, материалаар хангах		Бэлтгэсэн гарын авлага, материалын тоо	2	8	Татварын хуультай холбоотой 1 сонин, 9 гарын авлага бэлтгэн хэвлүүлж 400 татвар төлөгчид хүргүүлсэн	100
			Тараах материал, гарын авлага хүргүүлсэн татвар төлөгчийн тоо		300		
1.3	“ТАТВАР ТӨЛӨГЧ ТАНД БАЯРЛАЛАА”- аянг зохион байгуулах	ОНТ	Өдөрлөг зохион байгуулсан тоо	1	1	Татвар төлөгчдийн өдөрлөгийг 2023.05.08-12 ний өдрүүдэд ТЕГ-аас ирүүлсэн удирдамж төлөвлөгөөний дагуу ТАТВАР ТӨЛӨГЧ ТАНД БАЯРЛАЛАА уриан дор 1 удаа тэмдэглэн өнгөрүүлэв. Аянд 430 татвар төлөгч хамрагдсан. Татварын хэлтсийн даргын 11 сарын 01-ны өдөр баталсан тушаалын дагуу татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын удирдамж, болон ажлын төлөвлөгөөний дагуу сайнцагаан сумын татварын улсын байцаагч Зах худалдааны төвүүдийн 206 түрээслэгч татвар төлөгчдийн төлбөрийн баримтын олголтонд хяналт тавьж, зөрчил илэрсэн татвар төлөгчдөд гаргасан зөрчлийг арилгуулахаар шаардах хуудас, мэдэгдлийг гардуулан өгч ажиллалаа.	100
		20 сая	Аянд хамрагдсан татвар төлөгчийн тоо		400		

1	2	3	4	5	6	7	8
1.4	Дундговь аймгийн ЗДТГ-тай хамтран иргэдэд зориулсан татварын боловсрол нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах	ОНТ сая 5	Өдөрлөг зохион байгуулсан тоо  Өдөрлөгт хамрагдсан иргэдийн тоо		1  100	Хариуцлагатай татвар төлөгч аян 2 удаа зохион байгуулав. Тус аяны хүрээнд 14 сум, аймгийн төвийн нийт 213 татвар төлөгч хамрагдсан. Тус өдөрлөгөөр татвар төлөгчдийн зөвлөгөөн, спортын арга хэмжээ, төлбөрийн баримт олголт шалгалт зэргийг хийж гүйцэтгэсэн. Мөн 2022 оны тэргүүний 25 байгууллагыг шалгаруулсан. Холбогдох байгууллагуудтай хамтран баруун зүүн сумдын ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 39 ААН-үүдэд хяналт шалгалтыг зохион байгууллалаа.	100
1.5	Албан хаагчийг авлига, ашиг, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах		Зохион байгуулсан сургалтын тоо  Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо		1  30	ХАСХОМ, ХАСУМ гаргах арга зүйгээр хуулийн зөвлөх И.Замэндий 2 удаа, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн М.Ууганцэцэг 1 удаа давхардсан тоогоор 36 ЭБАТ нарт зориулан сургалт зохион байгуулсан.	100
1.6	Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хүргүүлэх		Тухайн жилийн тайлангийн тоо	1	1	ТЕГ-аас ирүүлсэн чиглэл, АЗДТГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу 2023 оны хөтөлбөрийн боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж тайланг 100 хувийн гүйцэтгэлтэй АЗДТГ, ТЕГ-т 4 удаа хүргүүлсэн	100
<b>ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ</b>							
1	Мэдээллийн ил тод байдлыг хангаж цахим хаягт мэдээллийг байршуулан баяжилт хийж ажиллана.		Мэдээлэл байршуулсан тоо	141	200	Засгийн газрын 374 дүгээр тогтоолын дагуу 5 бүлэг 98 үзүүлэлтээс хамаарах 49 шалгуур үзүүлэлт 230 мэдээлэл байршуулан баяжилт хийсэн. Пэйж хуудсандаа 1051 пост мэдээлэл байршуулсан бөгөөд нийт 97953 иргэн үзсэн байна. Мөн татварын албаны 1800-1288 тусгай дугаарт 10120 татвар төлөгчтэй холбогдож мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллав.	100

1	2	3	4	5	6	7	8
1.1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаар 9 мэдээллийн ил тод байдлыг хангах		Мэдээлэл байршуулсан тоо	67	90	Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтээр 24 үзүүлэлтэд 112 мэдээлэл байрлуулан ажилласан байна.	100
1.2	Хүний нөөцийн 7 мэдээллийг байршуулах		Мэдээлэл байршуулсан тоо	33	20	Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтээр 7 үзүүлэлтэд 21 мэдээлэл байрлуулан ажилласан байна.	100
1.3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх 10 мэдээллийг байршуулах		Мэдээлэл байршуулсан тоо	41	90	Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтээр 16 үзүүлэлтэд 97 мэдээлэл байрлуулан ажилласан байна.	100
<b>2</b>	<b>Архив албан хэрэг хөтлөлтийн хэрэгжилтийг ханган ажиллана</b>		<b>Хэрэгжилтийн хувь</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>Архив бичиг хэрэг хөтлөлтийн хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан</b>	100
2.1	Татвар төлөгч, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэх		Албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн хувь	100	100	Татвар төлөгчөөс 86, албан хаагчдаас 28 өргөдөл нийт 114 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэсэн.	100
			Татвар төлөгчдөөс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн хувь	100	100		
2.2	Байгууллагын ирсэн, явсан бичиг баримтад карт хөтлөх		Бүртгэл хийгдсэн хувь		100	Нийт 916 албан бичиг гаднаас ирж, 718 албан бичиг гадагш явуулж 100 хувь ERP системд бүртгэн карт хөтөлж байна	100
2.3	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт гаргаж, данс бүртгэл хөтлөх		Жагсаалт хөтөлсөн тоо		1	Хөтлөх хэргийн нэрийг жагсаалт гарган батлуулж 80 баримт бүртгэлжүүлсэн. Байнга, түр 70 жил хадгалах, устгах хэргийн актыг үйлдэж гаргасан.	100
2.4	Хариутай бичигт бүртгэл хяналтын карт хөтлөн, хяналт тавих		Хариутай бичгийн хариуг хүргүүлсэн хувь		100	Нийт 242 хугацаатай бичиг ирсэн бөгөөд Егр системд бүртгэж карт хөтөлж хариуг хугацаанд 100 хувь хүргүүлсэн	100
2.5	Баримт бичиг нягтлан шалгах комиссын хурал хийх		Комиссын хурал хийсэн тоо		1	Хэлтсийн даргын тушаалаар ажлын хэсэг байгуулж дүрэм батлан, хуралдааныг зохион байгуулан хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг тооцон ажилласан.	100

1	2	3	4	5	6	7	8
3	<b>Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг ханган ажиллана.</b>		<b>Хэрэгжилт ханган ажилласан хувь</b>	<b>93</b>	<b>90</b>	<b>Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийг 73 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.</b>	<b>73</b>
3.1	Дундговь аймгийн ЗДТГ, харьяа хэлтсүүдээс гаргасан захирамж, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах		Хэрэгжилтийг ханган ажилласан хувь	95	80	Нийт 22 удаагийн тайлан хэрэгжилтийг гаргаж 95 хувийн гүйцэтгэлтэйгээр хүргүүлсэн байна.	100
			Хэрэгжилт хүргүүлсэн тоо	22	15		
3.2	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн өөрийн байгууллагын болон холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлогын мэдээллийг бүрэн оруулах		Мэдээлэл байршуулсан хувь	98	100	Нийт 95 мэдээлэл оруулахаас 91 мэдээлэл байршуулж 95 хувь ханган ажилласан	97
			Мэдээлэл байршуулсан тоо	148	70		
3.3	Албан хаагч бүр хос бичгээр бичигдсэн нэрийн хуудас, энгэрийн тэмдэг хийлгэх		Нэрийн хуудас, энгэрийн тэмдэг хийгдсэн тоо		28	Хэлтсийн 9 өрөө, 28 албан хаагчийн мэдээллийг шинэчлэн энгэрийн тэмдэг, нэрийн хуудсыг шинэчилсэн.	100
3.4	Төв зам дагуу хуваарилагдсан газарт мод нөхөн тарилт хийж, арчлан ургуулах		Тарьсан модны тоо	320	200	Төв зам дагуу мод тариалахгүй гэсэн тул мод тариагүй.	-
			Мод ургалтын хувь	87	85		
3.5	Татварын албанд цахимаар татвар төлөх киоск машин авах	ОНТ 5.5 сая	Хэлтэст төхөөрөмж авсан тоо	-	1	Татварын хэлтсийн байранд АЗДТГ-ын санхүүжилтээр ГЭРЭГЭ КИОСК машин авч байрлуулан ашиглаж байна.	100
3.6	Сумдад татвар төлөх ПОС машин авах	ОНТ 10,8 сая	Сумдад төхөөрөмж авсан тоо	6	9	2023 онд ПОС машин авсан сум байхгүй. Манай албаны зүгээс татвар хураалтын үйл ажиллагаанд нэн шаардлагатай байгааг тус сумдын Засаг дарга удирдлагуудад удаа дараа тайлбарлаж байсан. Ялангуяа Татварын байцаагчгүй сумдад очиж ажиллахдаа Сайнцагаан сумын ПОС машиныг авч явж иргэд аж ахуйн нэгжийн татварыг хураахад ашиглан татвар төлөгчдийг олон тийш явуулахгүйгээр цаг завьг хэмнэсэн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ багийн дарга нар болон Засаг дарга сумдын удирдлагуудад сурталчилж сануулж байсан.	31



1	2	3	4	5	6	7	8
3.7	Татварын ерөнхий газраас баталсан зураг төсвийн дагуу шинэ байрны төсвийг 2024 онд төсөвт суулгах		Төсөвт төсөв суулгасан тоо		1	ТЕГазраас хийсэн нэгдсэн зураг төсвөөр аймгуудад Татварын хэлтсийн байр баригдаж байсан боловч 2022 онд тус зураг төсвийг өөрчлөх шаардлагатай гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан тул шинээр зураг төсөв хийлгэхээр төсвийн төслөө хүргүүлсэн. Мөн Сангийн сайд Жавхланг Дундговь аймагт ажиллахад хэлтсийн дарга биечлэн уулзаж, 2024 онд зураг төсвийн саналаа уламжилсан.	31
3.8	Сумдын татварын байцаагч нарыг бүрэн орон тоог нөхөн ажиллуулахад анхаарч ажиллах.		Сул орон тоо нөхсөн тоо	2	2	Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны захиалгыг 3 удаа хүргүүлсэн. Өлзийт, Луус, Цагаандэлгэр, Дэлгэрхангай сумдад шинээр татвар хураагч томилогдсон. Мөн аймгийн төвийн бичил, жижиг татвар төлөгчтэй харилцах тасагт 2 түр орон тоог төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэдээс нөхөж ажиллуулсан.	100
3.9	Боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах		Төлөвлөгөө боловсруулсан тоо		1	Захирамжийн хэрэгжилтийг хангуулахаар 30 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулсан.	100
			Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь		80	Татвар төлөгчид зориулсан төлөвлөгөөний хэрэгжилт 92 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.	
<b>Зорилтын дундаж хувь</b>							<b>97.0</b>
<b>Арга хэмжээний дундаж хувь</b>							<b>96.3</b>
<b>Үнэлгээний дундаж хувь</b>							<b>96.7</b>

Төлөвлөгөөг хянасан:  
**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА**  
(албан тушаал)  
Тэмдэг

Төсвийн Ерөнхийлөн захирагч  
..... /Ц.МӨНХБАТ/  
(гарын үсэг)  
(огноо).....

Төлөвлөгөө тайлагнасан:  
**ХЭЛТСИЙН ДАРГА**  
(албан тушаал)

Төсвийн Шууд захирагч  
..... /М.ТУЯАЦЭЦЭГ/  
(гарын үсэг)Тэмдэг (огноо).....